

БСБ - Төв Азийн Залуу бизнес эрхлэгчдийг дэмжих хөтөлбөр - ХасБанк хамтарсан санхүүжилт

Улс:	Монгол
Төслийн дугаар:	55861
Бизнесийн салбар:	Санхүүгийн байгууллагууд
Мэдэгдлийн төрөл:	Хувийн
Байгаль орчны ангилал:	СБ
Хэлэлцэх хурлын огноо:	2025 оны 1-р сарын 29
Төлөв байдал:	Зөвшөөрөл хүлээгдэж байгаа
Англи хэл дээрх ТХББ-ийг нийтэд ил болгосон өдөр: 2024 оны 12 дугаар сарын 25	

Төслийн танилцуулга

Төв Азийн Залуу бизнес эрхлэгчдийг дэмжих хөтөлбөр (YiB CA хөтөлбөр)-ийн хүрээнд Монголын хувийн хэвшлийн бичил, жижиг, дунд аж ахуйн нэгж (БЖДҮ)-үүдэд санхүүжилт үзүүлэх зорилгоор ХасБанк ХК-нд олгох 40 сая хүртэлх ам.долларын анхдагч өглөгт тооцогдох зээл (А-Зээл). Зах зээлийн нөхцөл байдлаас шалтгаалан Банк хамтран оролцогчдоос 120 сая ам.доллар (В-Зээл) хүртэлх нэмэлт санхүүжилт босгохыг эрмэлзэж ажиллана.

Төслийн зорилго

Санал болгож буй зээл нь (i) залуучуудын удирддаг / эзэмшдэг БЖДҮ-ийн сорилт ихтэй зах зээлийн орчны үр дагаврыг даван туулах, сөрөн тэсвэрлэх, дасан зохицох чадварыг нь нэмэгдүүлэх явдлыг дэмжих; (ii) санхүүжилтийн эх үүсвэрүүдийг нь төрөлжүүлэх; мөн (iii) залуу бизнес эрхлэгчдэд чиглэсэн санхүүгийн болон санхүүгийн бус үйлчилгээ (NFS) бүхий шинэ бүтээгдэхүүн гаргах боломжийг ХасБанкинд олгох бөгөөд улмаар эдгээр БЖДҮ-ийн санхүүгийн хүртээмж нэмэгдэх болно.

Шилжилтийн нөлөөлөл

Шилжилтийн нөлөөлөл 71

Төсөл нь YiB CA хөтөлбөрийн зорилгыг хангахад хувь нэмрээ оруулж, түүний хүртээмжтэй (анхдагч) болон өрсөлдөх чадвартай (хоёрдогч) байх чанарыг дэмжих болно. Энэхүү зээлийн шугам нь залуу бизнес эрхлэгчдэд олгох зээлийг нэмэгдүүлж,

ХасБанкны чадавхыг сайжруулан, тус орны залуу бизнес эрхлэгч / удирдлагуудын ур чадварыг сайжруулахад дэмжлэг үзүүлэх болно.

Зээлдэгчийн талаарх мэдээлэл

ХасБанк ХК

ХасБанк нь 1.7 тэрбум ам.долларын нийт актив, 975 сая ам.долларын зээлийн багцтай, зах зээлийн ойролцоогоор 8.8 хувийг эзэлж буй Монголын дөрөв дахь том арилжааны банк. ХасБанк нь санхүүгийн цогц үйлчилгээ нийт 71 салбар нэгжээр дамжуулан Монгол орон даяар үйл ажиллагаа явуулж буй байна.

ЕСБХБ-ны санхүүжилтийн тойм

40,000,000.00 ам.доллар

40 сая ам.долларын тэргүүн ээлжид төлөгдөх зээлийн санхүүжилт (А-зээл)

Төслийн нийт өртөг

160,000,000.00 ам.доллар

Хамтарсан санхүүжилтийн бусад оролцогчдоос 120,000,000 ам.доллар (В-Зээл) хүртэлх нэмэлт санхүүжилт босгох зорилготой бөгөөд үр дүн нь зах зээлийн нөхцөл байдлаас хамаарна.

Байгаль орчин, нийгмийн үйл ажиллагааны хураангуй

СБ ангилал (2019 БОНБ). ХасБанк нь ЕСБХБ-ны харилцагч бөгөөд ЕСБХБ-ны Гүйцэтгэлийн шаардлага (ГШ) 2, 4, 9-ийн шаардлагуудыг хангасан Байгаль орчны бодлого, Байгаль орчин, нийгмийн харилцааны журмуудыг батлан гаргасан. ХасБанк нь ГШ 2, 4, 9-ийг, улмаар ЕСБХБ-ны Компанийн зээл, ЖДҮ болон бичил зээлтэй холбогдох Байгаль орчин, нийгмийн харилцааны журам, Худалдааны санхүүжилт (TFP)-ийн Байгаль орчин, нийгмийн харилцааны журмуудыг дагаж мөрдөх ёстой бөгөөд ЕСБХБ-ны Байгаль орчин, нийгмийн харилцааны Үл зөвшөөрөх асуудлын жагсаалтын шинэчилсэн хувилбар, мөн 2019 оны Байгаль орчин, нийгмийн бодлого (ESP 2019)-оор нэвтрүүлсэн Хяналтын жагсаалтыг дагаж мөрдөх, жилийн Байгаль орчин, нийгмийн тайланг Банкинд ирүүлж байх шаардлагатай. ХасБанкны зээлдэгчид үндэсний байгаль орчин, эрүүл мэнд, аюулгүй байдал болон хөдөлмөр хамгаалалттай холбогдох шаардлагуудыг дагаж мөрдөх үүрэгтэй.

Санал болгож буй зээлийн хүрээнд санхүүжих үйлчлүүлэгчид цаашид Бодлогын мэдэгдлийн дагуу Эрчим хүчний хэмнэлт, Нөөцийн үр ашигтай зарцуулалт, Сэргээгдэх эрчим хүчний төслүүдэд тавигдах Байгаль орчин, нийгмийн шалгуур үзүүлэлтүүд болон Ногоон эдийн засгийн шилжилт (GET)-ийн бусад шалгуурыг дагаж мөрдөх шаардлагатай болно.

Техникийн хамтын ажиллагаа

Төв Азийн Залуу бизнес эрхлэгчдийг дэмжих хөтөлбөрт техник хамтын ажиллагаа (ТХА)-ны гурван бүрэлдэхүүн хэсэг багтсан. Үүнд:

- i. ХасБанкны онцлогт тохируулсан чадавх бэхжүүлэх ТХА. Санхүүжилтийн эх үүсвэр: ЕСБХБ-ны Хувь нийлүүлэгчдийн тусгай сан ("SSF").

- ii. БЖДҮ дэмжих хөтөлбөр (ASB)-өөр дамжуулан залуу бизнес эрхлэгчдийн чадавхыг бэхжүүлэх. Санхүүжилтийн эх үүсвэр: Хувь нийлүүлэгчдийн тусгай сан ("SSF").
- iii. ХасБанкны кибер аюулгүй байдлын дүн шинжилгээг Банкны онцлогт тохируулан хийх ТХА. Санхүүжилтийн эх үүсвэр: Тайпэй, Хятад.

Хамтарсан хөрөнгө оруулалтын буцалтгүй тусламж / Хөнгөлөлттэй санхүүжилт (ТХА бүс)

- i. ХасБанкнд зориулсан Анхдагч алдагдлын эрсдэлийн даатгал: А-Зээлийн 5 хүртэлх хувь; нэг дэд зээл тутамд 70 хүртэлх хувиар хязгаарлагдана. Санхүүжилтийн байдал: Санхүүжилтийг ЕХ-ны "Ковид-19-ийн дараах Монгол Улсад хямралд тэсвэртэй ЖДҮ-ийг бий болгох" төсөл болон Хувь нийлүүлэгчдийн тусгай сан ("SSF")-аас авахаар төлөвлөж байна.
- ii. ХасБанкнд зориулсан үр дүнд суурилсан нөхөн олговор: Yib зээлийн тогтвортой тэлэлтийг бий болгохтой холбоотой урьдчилсан хөрөнгө оруулалтыг үйлчлүүлэгчид хэсэгчлэн нөхөн олгох зорилго бүхий А-Зээлийн 3 хүртэлх хувьтай тэнцэх дүн. Санхүүжилтийн эх үүсвэр: Хувь нийлүүлэгчдийн тусгай сан ("SSF").

Нэмэлт ашиг тус

Санхүүжилтийн бүтэц:

ЕСБХБ нь Монголд урт хугацааны санхүүжилт олгодог цөөхөн байгууллагуудын нэг хэвээр байна. Гурван жилийн хугацаатай санхүүжилт олгох нь дэд зээлдэгчдийн урт хугацааны зээлийн эрэлт, ялангуяа зээлийг хөрөнгө оруулалт хэлбэрээр ашиглах дэд зээлдэгчдийн эрэлт хэрэгцээг илүү сайн хангах бөгөөд энэ нь залуу бизнес эрхлэгчдийн эрэлт хэрэгцээнд онцгой нийцэж чадна.

Санхүүжилтийн шинэлэг бүтэц ба/эсвэл хэрэгслүүд:

Тус төсөл нь тусгайлан зориулж боловсруулсан, Монголын зах зээлийн хувьд шинэлэг хэрэгслүүд болох Анхдагч алдагдлын эрсдэлийн даатгал ("FLRC") болон Үр дүнд суурилсан нөхөн төлбөр ("RBC")-өөс ашиг тус хүртэх болно. FLRC болон RBC нь бага буюу илүү уян хатан барьцааны шаардлагыг санал болгоход нь ХасБанкид дэмжлэг үзүүлэх зорилготой юм.

Стандарт тогтоох: төслүүд болон үйлчлүүлэгчдэд илүү өндөр стандартад хүрэхэд нь туслах:

Төв Азийн Залуу бизнес эрхлэгчдийг дэмжих хөтөлбөр нь санхүүжилтийн элементүүд (санхүүжилт, FLRC, RBC ба ТХА)-ийг хослуулан, залуу бизнес эрхлэгчид санхүүгийн үйлчилгээ бага авч байгаа хэсэг (сегмент)-ийн эрэлт хэрэгцээний талаар илүү сайн мэдлэг, ойлголт бий болгох замаар үйлчлүүлэгчдэд хүртээмжтэй санхүүжилтийн стандартыг дээшлүүлэхэд тус дөхөм үзүүлнэ. Цаашилбал, ТХА-ны иж бүрэн багц нь бүтээгдэхүүн, түүнийг хүргэх механизмаа залуу бизнес эрхлэгчдийн хэрэгцээнд нийцүүлэн өөрчлөхөд нь үйлчлүүлэгчдэд дэмжлэг үзүүлж, улмаар тухайн сегментийн боломж чадавхыг ашиглах, санхүүгийн хүртээмжийг өргөтгөх боломжийг ХасБанкинд олгоно.

Мэдлэг, инновац, чадавхыг бэхжүүлэх:

Оролцогч санхүүгийн байгууллагуудад үзүүлэх ТХА болон БЖДҮ дэмжих хөтөлбөр (ASB)-өөр дамжуулан, залуучуудын БЖДҮ-д зориулсан сургалт, зөвлөх үйлчилгээнээс бүрдсэн өргөн хүрээний чадавхыг бэхжүүлэх үйл ажиллагаа Yib CA хөтөлбөрт багтах

бөгөөд энэ нь орон нутгийн зах зээлд байхгүй байж болох мэдлэг, туршлага олж авах, үр шимийг нь хүртэх боломжийг бүх талуудад олгох болно.

Компанийн холбоо барих мэдээлэл

Эрдэнэбаяр Ганзориг

И-мэйл: erdenebayar.g@xacbank.mn

Утас: +(976) 7577-1888 (+826), +(976-11) 328701

<https://www.xacbank.mn/en>

ХасБанкны төв байр, Улаанбаатар хот 14200, Шуудангийн салбар 20А,
Шуудангийн хайрцаг – 72, Монгол улс.

Шилжилтийг ойлгох нь

Шилжилтийн нөлөөллийг хэмжих чиглэлд ЕСБХБ-ны баримталдаг арга хандлагын талаарх нэмэлт мэдээллийг [эндээс](#) авна уу.

Бизнес боломжууд

Бизнес боломжууд болон худалдан авалтын талаар үйлчлүүлэгч компанитай холбогдоно уу.

ЕСБХБ-тай хамтран ажиллах боломжууд (худалдан авалттай холбоогүй)-ын талаар сонирхвол дараах утасны дугаар, цахим хаягаар холбоо барина уу.

Утас: +44 20 7338 7168

Цахим шуудан: projectenquiries@ebrd.com

Төрийн хэвшлийн төслүүдтэй холбоотой мэдээлэл авахыг хүсвэл [ЕСБХБ-ны Худалдан авалт](#) хэсэгт зочилно уу.

Утас: +44 20 7338 6794

Цахим шуудан: procurement@ebrd.com

Ерөнхий лавлагаа

Дэлгэрэнгүй лавлагааг [ЕСБХБ-ны Лавлагааны маягт](#) ашиглан авах боломжтой.

Байгаль орчин, нийгмийн бодлого (БОНБ)

[БОНБ](#) болон холбогдох Гүйцэтгэлийн Шаардлагууд (ГШ) нь ЕСБХБ-ны “байгаль орчинд ээлтэй, тогтвортой хөгжил”-ийг хөхиүлэн дэмжих үүрэг амлалтаа биелүүлэхэд баримтлах арга замуудыг тодорхойлдог. БОНБ болон ГШ-д үйлчлүүлэгчийн зүгээс олон нийтийн мэдээлэл, хэлэлцүүлгийн талаарх үндэсний хууль тогтоомжийн холбогдох заалтуудыг дагаж мөрдөх, мөн оролцогч талуудын санал гомдол, ялангуяа үйлчлүүлэгч ба төслийн байгаль орчны болон нийгмийн гүйцэтгэлийн талаарх санал гомдлыг хүлээн авч, шийдвэрлэдэг

гомдол барагдуулах механизм бий болгох тухай тодорхой заалтууд багтсан байдаг. ЕСБХБ нь аливаа төслийн байгаль орчны болон нийгмийн эрсдэл, нөлөөллийн мөн чанар, цар хүрээнд дүйцүүлэн, тухайн төслийн улмаас үүсэх эрсдэл, үр нөлөөллийн тухай мэдээллийг шаардлагын дагуу ил болгох, эсвэл оролцогч талуудтай утга учиртай зөвлөлдөх, тэдний санал хүсэлтийг харгалзан үзэж, хариу өгөх нэмэлт шаардлагыг үйлчлүүлэгчиддээ тавьдаг.

Энэ чиглэлд ЕСБХБ-ны хэрэгжүүлдэг практикийн талаарх нэмэлт мэдээллийг [БОНБ](#)-д оруулсан болно.

Бүрэн төгс байдал ба комплаенс

ЕСБХБ-ны Комплаенс хариуцсан Захирлын Ажлын алба (КЗАА) нь сайн засаглалыг хөхиүлэн дэмжиж, олон улсын шилдэг практикт нийцүүлэн Банкны бүхий л үйл ажиллагаан дахь бүрэн төгс байдлыг хамгийн дээд стандартаар хангахад анхаарч ажилладаг. Төслүүдийн зүгээс Банкинд бүрэн төгс байдал, нэр хүндийн хувьд хүлээн зөвшөөрөх боломжгүй эрсдэл үүсгэхгүй байх нөхцлийг хангахын тулд тус Банк бүх үйлчлүүлэгчийнхээ бүрэн төгс байдалд нарийвчилсан үнэлгээ хийдэг. Банк аливаа асуудлыг төслийн үнэлгээг батлах үе шатанд илрүүлэн тогтоож, шийдвэрлэх нь Банкны транзакцийн бүрэн төгс байдлыг хангах хамгийн үр дүнтэй арга зам гэж үзэж байна. КЗАА нь эдгээр хамгаалалтын арга хэмжээг авахад голлох үүрэг гүйцэтгэж, мөн төслүүдийн хөрөнгө оруулалтын дараах бүрэн төгс байдлын эрсдлийг хянахад тус дөхөм үзүүлдэг.

Түүнчлэн, КЗАА нь ЕСБХБ-ны санхүүжүүлсэн төслүүдтэй холбоотой залилан мэхлэлт, авилга, хээл хахууль болон буруу үйлдлийн талаарх гомдлын мөрөөр судлан шалгах үүрэгтэй. Банкны ажилтнууд, эсвэл гадна байгаа хэн ч бай залилан мэхлэлт болон авилгал үйлдэгдсэн хэмээн сэжиглэж буй тохиолдолд Комплаенс хариуцсан захиралд compliance@ebrd.com цахим шуудангийн хаяг руу бичгээр илтгэх ёстой. Мэдээлэгдсэн бүхий л асуудлын мөрөөр хянан шийдвэрлэх ажлыг КЗАА гүйцэтгэнэ. Нэр хаягтай болон нэр хаяггүй бүх мэдээллийг шалгана. Мэдээллийг Банкны албан ёсны хэл болон үйл ажиллагаа явуулдаг улс орнуудын хэлний алинаар ч үйлдэж болно. Ирүүлсэн мэдээлэл нь чин сэтгэлийн байх ёстой.

Мэдээллийн хүртээмжийн бодлого (МХБ)

МХБ нь 2020 оны 1 дүгээр сарын 1-нээс хүчин төгөлдөр хэрэгжиж эхэлснээс хойш ЕСБХБ мэдээллийг хэрхэн олон нийтэд ил тод болгох, өөрийн стратеги, бодлого болон үйл ажиллагааны талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэн сурталчлах чиглэлд оролцогч талуудтай хэрхэн зөвлөлдөх арга замуудыг тодорхойлсон байдаг. ЕСБХБ-ны вэб сайтаас ямар мэдээлэл авах боломжтойг мэдье гэвэл [Мэдээллийн хүртээмжийн бодлого](#) хуудсанд зочилно уу.

Мэдээлэл авах тодорхой хүсэлтээ [ЕСБХБ-ны Лавлагааны маяг](#) ашиглан илгээх боломжтой.

Төслийн хариуцлагын хараат бус механизм (ТХХБМ)

Хэрэв байгаль орчин, нийгэм болон мэдээллийн ил тод байдалтай холбоотой санал гомдлоо үйлчлүүлэгч болон Банкинд тавьж шийдвэрлүүлэх (жишээлбэл: үйлчлүүлэгчийн Төслийн түвшний гомдол барагдуулах механизмаар дамжуулж, эсвэл Банкны удирдлагатай шууд харилцах замаар) оролдлого, хүчин чармайлт нь амжилтгүй болвол, хувь хүн болон байгууллагууд санал гомдлоо ЕСБХБ-ны Төслийн хариуцлагын хараат бус механизм (ТХХБМ)-аар дамжуулан шийдвэрлүүлэхийг зорьж болно.

ТХХБМ нь Төсөлтэй холбоотой бусдад хор хохирол учруулсан (эсвэл учруулж болзошгүй) гэж үзэж буй асуудлуудыг хараат бусаар хянан шалгадаг. Энэхүү Механизмын зорилго нь байгаль орчин, нийгэм болон мэдээллийн ил тод байдалтай холбогдох асуудлуудыг шийдвэрлэх талаар Төслийн оролцогч талуудын хоорондох яриа хэлэлцээг дэмжих; Банк өөрийн [Байгаль орчин, нийгмийн бодлого](#), эсвэл [Мэдээллийн хүртээмжийн бодлого](#)-ын Төсөлд холбогдох заалтуудыг дагаж мөрдсөн эсэхийг тогтоох; мөн шаардлагатай тохиолдолд Банкны зүгээс эдгээр бодлогод үл нийцсэн зөрчлийг арилгах, түүний зэрэгцээ цаашид тийм зөрчил гарахаас урьдчилан сэргийлэхэд оршино.

ТХХБМ болон түүний эрх үүргийн талаар илүү ихийг мэдэхийг хүсвэл [Төслийн хариуцлагын хараат бус механизмын вэб сайт](#), хянан шалгуулах хүсэлт тавих бол [Хүсэлт](#) хаягаар тус тус хандана уу. Эсвэл ТХХБМ-ын талаар, мөн санал хүсэлт хэрхэн тавих тухай чиглэл заавар, нэмэлт мэдээлэл авах бол ipam@ebrd.com цахим шуудангаар хандаж болно.